

МОНОС  
ХҮНС

Hazard Analysis  
HACCP  
Certificate of Compliance

International Organization for Standardization  
ISO  
9001 - 2015

Эрццл  
хүнс, хүн



2020 ОНЫ ЭХНИЙ  
ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН



М. ИНОС  
TASTE  
TASTE

М. ИНОС  
TASTE  
TASTE

ТASTE  
TASTE  
TASTE

ЭКО  
ЭКО  
ЭКО

ЭКО  
ЭКО  
ЭКО

ЭКО  
ЭКО  
ЭКО

ЭКО  
ЭКО  
ЭКО

ЭКО  
ЭКО  
ЭКО

ЭКО  
ЭКО  
ЭКО

ЭКО  
ЭКО  
ЭКО

ЭКО  
PHOS  
ЭКО

ЭКО  
ЭКО  
ЭКО



# АГУУЛГА

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

КОМПАНИЙН НИЙГМИЙН  
ХАРИУЦЛАГА

ХАГАС ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН



# МОНОС ХҮНС

Монос Хүнс ХК нь 2012 оноос хүн амын эрүүл мэндийг дэмжих хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэн худалдаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Бид үндэстний онцлогтой уламжлалт цагаан идээ болон Монгол орны хөрсөнд ургасан анагаах удистай түүхий эдийг ашиглан тэргүүлэх зэргийн эрдэмтэн судлаачдын олон жилийн судалгаанд үндэслэн бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг. Нийт 8 брэндийн 87 төрлийн эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж Монгол орны 4 зүг найман зовхист бараа бүтээгдэхүүнээ хүргэх үүднээс нийслэл, 21 аймгийн нийт 6.000 цэгт түгээлт хийдэг.

87 ТӨРЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ

21 АЙМГИЙН

НИЙТ 6,000 ЦЭГТ  
ТҮГЭЭЛТ ХИЙДЭГ

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрүүл мэндийг дэмжих хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн сэтгэл ханамжид нийцүүлэн, олон улсын стандартаар **ҮЙЛДВЭРЛЭГЧ, ЭКСПОРТЛОГЧ**, дотоодын зах зээлд **ТЭРГҮҮЛЭГЧ** компани байна

## АЛСЫН ХАРАА

**ЭРҮҮЛ** мэндийг дэмжсэн органик хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн өдөр тутмын хэрэглээнд нэвтрүүлэх

## ҮНЭТ ЗҮЙЛ

Эрүүл чанартай бүтээгдэхүүн

Эрхэм хэрэглэгч

Итгэлтэй харилцагч

Ёс зүйтэй бизнес

Мэдлэг чадвартай бүтээлч  
хамт олон

Шинэ санал санаачлага



**Л. ХҮРЭЛБААТАР**

МУ-ын төрийн шагналт, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, Эм зүйн ухааны доктор профессор, Академич, Монос группийн ТУЗ-ийн дарга

## **ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ**

Хүн ардын эрүүл оршихуйг дээдлэн зүтгэсэн 30 жилийн туршлага, судалгаа шинжилгээнд үндэслэн Монос Хүнс ХК нь дахин давтагдашгүй үндэсний онцлогтой бүтээгдэхүүнүүдийг ард иргэдийнхээ эрүүл мэндийн төлөө хоёргүй сэтгэлээр үйлдвэрлэсээр ирлээ. Бид “Монос Хүнс” компанитай хамтдаа хөгжих, ашиг хүртэх боломжийг хүн бүрд олгох үүднээс 2019 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр IPO гаргаж 4,000 гаран хувьцаа эзэмшигчидтэй болсон. Нийт хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ ухамсарлаж амлалтуудаа алхам алхмаар биелүүлсээр байна.

Дэлхий дахинд дэгдээд буй COVID-19 вирусийн тархалттай холбоотойгоор Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх уриалгыг хүлээн авч 2020 оны 4 сарын 27-ны өдөр технологийн шийдлийг ашиглан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа цахим орчинд дуу, дүрсний алдагладгүй амжилттай зохион байгуулсан юм. Уг хурлаар хувьцаа эзэмшигчдэдээ компанийн үйл ажиллагаа, ашиг орлогоо нээлттэй танилцуулан 408,8 сая төгрөгийн ногдол ашиг хүртээх шийдвэр гаргасан нь Хувьцаат компани болсон эхний жилдээ ногдол ашиг хуваарилах амлалтаа биелүүлсэн нэг алхам боллоо.

Мөн 2020 оноос эхлэн Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индекс, Хамгийн өндөр үнэлгээ бүхий компаниудын ТОП-30-д орж, хамгийн сүүлд Хөрөнгийн биржийн самбарын ангилал ахиж 1-р ангиллын Хувьцаат Компани болсныг дуулгахад таатай байна.

Олон улсын стандартаар ҮЙЛДВЭРЛЭГЧ, ЭКСПОРТЛОГЧ, дотоодын зах зээлд ТЭРГҮҮЛЭГЧ компани байх зорилгынхоо хүрээнд АНУ-ын Хүнс Эмийн Зөвшөөрөл (FDA)-ийн байгууллагад эрүүл мэндийн хүнсний үйлдвэр эрхлэгч гэсэн бүртгэлийг амжилттайгаар хийлгээд байна. Ингэснээр АНУ-д албан ёсоор экспорт хийх боломж нээгдэж байгаа юм.

Цаг үеийн төвөгтэй, хүнд нөхцөл байдлын энэ үед өнгөрсөн оны мөн үеэс 18 хувийн өсөлттэй ажиллаж чадсан нь нийт ажилтан албан хаагчид, хэрэглэгчид, хамтран ажиллагчид, хөрөнгө оруулагчид та бүхний дэмжлэг, оролцооны үр дүн юм.

Бидэнд өндөр итгэл хүлээлгэж хөрөнгө оруулалт хийсэн хувьцаа эзэмшигчдэдээ болон амжилт ололт бүхний ард зүрх сэтгэлээ зориулан ажилладаг Монос Хүнс ХК-ийн удирдлагууд, нийт ажилтнууддаа чин сэтгэлийн талархлаа илэрхийлж эрүүл энхийг хүсэн ерөөе.

# ТҮҮХЭН ЗАМНАЛ



## 2011 он

Монос группийн ерөнхийлөгч Л.Хүрэлбаатарын тушаалаар "Монос фарм" ХХК-ийн үйлдвэрлэж байсан зарим хүнсний зориулалттай бүтээгдэхүүнийг таслан авч эм биш эрүүл мэндийг дэмжих хүнс болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг байгуулж, эхний туршилтыг амжилттай хийв.



## 2012 он

"Монос Хүнс" ХХК албан ёсоор байгуулагдаж УБЕГ-т бүртгүүлж гэрчилгээгээ гардан авав. Ус, ундааны үйлдвэрлэлийг ашиглалтад оруулж ПЕТ / хуванцар/ болон шилэн савлагаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргаж эхэлсэн. Мөн үзэмтэй болон витаминт үрэл, Гоолингоо тураах цай, Аньс, Нэрс, Чацаргана жимсний чанамал зэрэг бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж эхэлсэн.

## 2013 он

Цэнэг брэндийн Дархлаа, Бөөр хамгаалах, Алтангагнуур, Нохойн хошуу, Таурин, Улаан чавга, Коллагентай бэлдмэлийг шилэн савлагаатай гаргасан. Хаан жимс брэндийн чацарганын өтгөрүүлсэн шүүс болон шууд уух ундааг ПЭТ савлагаатай гаргасан. Мөн Энхжин брэндийн Алтангагнууртай, Чага мөөгтэй цайг худалдаанд гаргав.



## 2014 он

Компанид ERP системийг нэвтрүүлэв. Энхжин брэнд Уушги цэвэрлэх цай, Бөөр хамгаалах цай, Чихрийн шижингийн цайгаар төрлөө нэмлээ.



## 2015 он

Монос Группийн 25 жилийн ойд зориулан Эко эрүүл мэндийн ус болон МУИС, Эм судлалын хүрээлэнтэй хамтран хөгшрөлтийн эсрэг антиоксидант үйлдэл бүхий "100 наслаарай" цайг бүтээж худалдаанд гаргасан. Цэнэг брэндийг хэрэглэхэд хялбар уутан /pouch/ савлагаатайгаар зах зээлд дахин нэвтрүүлэв.

## 2017 он

Эко уусдаг цайны цехийн хүчин чадлыг 4 дахин нэмэгдүүлэн ус, ундааны цехэд Pouch савлагаатай ундаа савлах 4 замтай тоног төхөөрөмж суурилуулав. Үндэсний контент Маамуу хүүхэлдэйн киноны өхөөрдөм хоёр гол дүр Аами, Таамигийн нэрээр нэрлэгдсэн ундаа, үзэмтэй үрлийг үйлдвэрлэж эхэллээ. ЭКО уусдаг цай нь Өгөг сүүтэй цайгаар төрлөө нэмж, BerryVit брэндийн аньс, нэрс, чацаргана, тарагтай ааруултай үрэл шинээр худалдаанд гарав. Энхжин брэндийн Уушги цэвэрлэх цай шинэчлэгдэн зах зээлд нэвтэрлээ. Мөн ISO 9001:2015 болон HACCP стандарт нэвтрүүлэх төслийн ажил эхлэв.



## 2016 он

Импортыг орлох аньс, нэрс, чацаргана жимстэй 3 төрлийн Эко уусдаг цай Монголдоо анх удаа үйлдвэрлэн худалдаанд гаргасан. Мөн ERP систем ашиглан борлуулалтын захиалга авч эхэлсэн.





## 2018 он

Энхжин брэндийн Цэвэрлэх цай болон Бөөр хамгаалах цай шинэчлэгдэн худалдаанд гарсан. Дэлхийд чанар стандартаар тэргүүлдэг Япон улсын "Pocket mart" сүлжээ дэлгүүрээр Монголын цор ганц "Эко" уусдаг цайгаа худалдаалж эхэлсэн. Мөн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн хотод нэрийн барааны дэлгүүрээ нээлээ. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимаас анх удаа Үндэсний үйлдвэрлэгч Entrepreneur-2018 шагналыг хүртэв.

## 2019 он

"Монос Хүнс" компани Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анх удаа олон нийтэд нээлттэй хувьцаагаа арилжаалж эхэллээ. Хувьцаа эзэмшигчдийн хамтаар босгосон 8,5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр "Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэр"-ийг барих ажлыг эхлүүлсэн. Мөн Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартуудыг хэрэгжүүлж буйгаа баталгаажуулан гэрчилгээгээ гардан авав. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас Үндэсний үйлдвэрлэгч Entrepreneur-2019 шагналыг 2 дахь удаагаа гардан авлаа.



## 2020 он

"Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэр"-ийг ашиглалтад оруулав. "Экос" эрүүл мэндийн усны савлагааг шинэчлэн "Оргилуун зөөлөн" усаар нэр төрлөө нэмсэн. "Бэрривит" брэнд аарцтай, тоглоомтой үрлээр нэр төрлөө нэмлээ. Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэртээ 7 төрлийн Vitos шот савлагаагаатай эрүүл мэндийн бэлдмэл, 5 нэр төрлийн Craft tea брэндийг шинээр үйлдвэрлэх бэлтгэл ажил явагдаж байна. Мөн аарцтай витаминт үрэл "Тугал" брэнд, цагаан гаатай уусдаг цай "Tastea" брэндийг зах зээлд нэвтрүүллээ. Чанарын удирдлагын тогтолцоо ISO22000:2018, Хүний нөөцийн менежментийн ISO:30400 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэв.

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



## Л.ХҮРЭЛБААТАР

Монос Хүнс ХК-ийн ТУЗ-ийн дарга,  
Монос группийн ерөнхийлөгч

## ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮД



### Х.Ананд

Стратеги, бизнес  
хөгжлийн хорооны  
дарга  
Монос группийн  
гүйцэтгэх захирал



### Х.Солонго

Цалин  
урамшууллын  
хорооны дарга  
Монос Косметик  
ТУЗ-ийн дарга



### Ц.Цэцэгбадам

Аудитын хорооны  
гишүүн  
Цалин урамшууллын  
хорооны гишүүн  
Монос группийн  
Санхүү эрхэлсэн  
захирал



### А.Отгондарь

Монос хүнс ХК-  
ийн гүйцэтгэх  
захирал



### Ч.Баттогтох

Цалин  
урамшууллын  
хорооны гишүүн  
АШУҮИС-ийн  
Тэнхимийн эрхлэгч

## ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



### Б.Гантулга

Аудитын хорооны  
дарга  
Стратеги, бизнес  
хөгжлийн  
хорооны гишүүн  
Ард Лайф ХХК-  
ийн гүйцэтгэх  
захирал



### Н.Долгормаа

Аудитын хорооны  
гишүүн  
Голомт фaйнэншил  
группийн санхүү  
хариуцсан захирал



### Ч.Чинзориг

Цалин урамшууллын  
хорооны гишүүн  
Стратеги, бизнес  
хөгжлийн хорооны  
гишүүн  
Тандем Глобал  
ложистик  
Монголи ХХК-ийн  
гүйцэтгэх захирал





# ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монос группийн хэмжээнд анх удаа Монос Хүнс компани Монголын хөрөнгийн бирж дээр MFC бүртгэлийн кодтойгоор хувьцаагаа арилжаалж эхэлсэн юм. Бид “Эрүүл мэндийн төлөө итгэлтэй хөрөнгө оруулалт” гэсэн уриан дор хэрэглэгчдийнхээ эрүүл мэндийг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх олон улсын стандартад нийцсэн шинэ үйлдвэрийг бүтээх зорилгоор IPO гаргасан билээ.

2019 оны 4-р сарын 22-ны өдрөөс 2019 он 5-р сарын 03-ны өдөр хүртэлх Эрүүл мэндийн төлөө итгэлтэйгээр хөрөнгө оруулалт хийсэн 4,000 гаруй хувьцаа эзэмшигчдийнхээ хамтаар олон улсын GMP стандартыг хангасан 1,772 метр квадрат талбай бүхий “Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэр”-ийг ашиглалтад оруулсан.

## Үйлдвэрлэлийн хүчин чадал

### Шингэн хүнсний үйлдвэр



### САВЛАГААНЫ ШУГАМ

ХАЛУУН 4,000 ЦАГТ ШИРХЭГ

ХҮЙТЭН 6,000 ЦАГТ ШИРХЭГ

### Хуурай хүнсний үйлдвэр

ЦАЙ 12,000 ЦАГТ ШИРХЭГ

ҮРЭЛ 12,000 ЦАГТ ШИРХЭГ

## Байгальд ээлтэй үйлдвэрлэл



Бүтээгдэхүүний сав баглаа боодолдоо хог хаягдлыг ангилан хаях олон улсын стандартыг нэвтрүүлж хялбар таслах шугамыг бүтээгдэхүүний шошгондоо ашиглаж эхлээд байна.



**Цахилгаан:** Үйлдвэрийн хэмжээнд байгальд ээлтэй, эрчим хүч бага зарцуулдаг LED гэрэлтүүлэг, эрчим хүчний хэмнэлт бүхий А+ ангиллын цахилгаан хэрэгслүүдийг ашигласнаар 14-20%-ийн цахилгааны хэмнэлт хийдэг.



**Ус:** Усны хэрэглээг багасгах, зөв зохистой хэрэглээ бий болгох үүднээс үйлдвэрлэлээс гарсан саарал усыг өөрсдийн ахуй хэрэглээндээ ашиглаж байна.

# Энхжин

## ЭНХ МӨНХ АМЬДРАЛЫГ ТЭТГЭГЧ

Эмнэх чадвар, биологийн идэвхт үйлдлээрээ үл орлогдох Эмийн ургамлуудыг олон жилийн туршилт судалгааны үндсэн дээр Эм Судлалын Хүрээлэнтэй хамтран хөгжүүлж Инноваци шингэсэн эрүүл мэндийн Энхжин цайны цувралыг эрхэм хэрэглэгчдэдээ хүргэдэг.

Энхжин цайнд орсон ургамал тус бүрийг биологийн идэвхт бодисын агууламж хамгийн өндөр үед нь түүн бэлтгэж, тусгай технологиор боловсруулдаг тул өдөр тутамдаа ууж хэрэглэснээр өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.



Эмчилгээний үед өөрт тохирох Энхжин цайны төрлийг сонгон хэрэглэснээр эмчилгээний үр дүнд сайнаар нөлөөлж хурдан илааршихад тустай.





## ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН УС

Монос Хүнс ХК хүн амын өвчлөлийн жагсаалтын тэргүүн эгнээд байгаа ходоодны өвчлөлийг бууруулах зорилготойгоор Экос эрүүл амьдралын усыг 3 жилийн өмнөөс үйлдвэрлэж эхэлсэн юм. Ходоодны хүчил, шүлтийг тэнцвэржүүлэх үйлчилгээтэй рН 8.5-тай ЭКОС шүлтлэг, зөөлөн усыг Монгол түмний эртнээс уламжилж ирсэн хужир ашиглан шүлтлэгжүүлдэг ба ходоодны үрэвсэл, улайлт, шархны эдгэрэлтийг түргэсгэх, хүчил шүлтийн балансыг тэнцвэржүүлэхэд тустай.



SPARKLING

### Экос зөөлөн оргилуун

Байгалийн хужраар шүлтлэгжүүлж, эрдэсжүүлсэн Экос зөөлөн усыг хийжүүлснээр таатай зөөлөн сэргээх мэдрэмж өгөх юм. Ямар нэгэн нэмэлт амт, үнэр оруулагч бодис ороогүй хийжүүлсэн усыг хэрэглэх нь эрүүл мэндэд эерэг нөлөөтэй юм. Учир нь хийжүүлсэн ус нь цатгалан мэдрэмж өгч жингээ хасахад эерэг нөлөө үзүүлдэг бөгөөд өтгөн хаталтыг бууруулдаг байна.

### Экос эрдэс нөхөгч

Биеийн ачааллаас шалтгаалан хөлс ихээр ялгаруулдаг хүмүүст зориулан изотоник буюу “эрдэс нөхөгч” усыг зах зээлд шинээр нэвтрүүлэхээр бэлдээд байна. “Экос” зөөлөн усны нэг төрөл болох “Экос” эрдэс нөхөгч ус нь найрлагадаа хөлсөөр дамжуулан алддаг 7 төрлийн эрдэс бодисыг зохистой хэмжээгээр агуулсанаар шөрмөс татах, эрхтэн системийн доголдол үүсэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.



pH 8.5



ISOTONIC

# ИМПОРТЫГ ОРЛОХ ЭКО УУСДАГ ЦАЙ

Монгол хүний оюун сэтгэлгээгээр бүтсэн Монголын анхны бөгөөд цор ганц уусдаг цай бол Эко брэнд юм. Эко уусдаг цай нь аньс, нэрс, чацаргана жимсний болон Өег сүүтэй цай гэсэн 4 нэр төртэй Аньс, нэрс, чацаргана жимстэй Эко уусдаг цай нь олон төрлийн амин дэмийг өөртөө агуулсан учраас биеийн дархлааг дэмжих, хаван хөөх, шээс ялгаралтыг дэмжих зэрэг олон эерэг нөлөөтэй.

Өег сүүтэй цай нь сулийн гурил, халтар арвайн гурил, шар будаа, өрөм, хужир, шүдэн уулын жамц давс, хатаасан сүү, цайны ханд зэрэг орц найрлагатай цэвэр экологийн бүтээгдэхүүн юм.



Монгол орны хөрсөнд ургасан зэрлэг жимс, тариа буудайг шимт чанар нь хамгийн өндөр үед сорчлон бэлтгэж, хиймэл үнэр амт орлуулагч, будагч бодис хийлгүй тусгай технологийн дагуу бэлтгэсэн Эко цай нь биеийг сэргээж, эрч хүч, дархлааг дэмжих болно. Аялал зугаалга, завгүй ажлын өдрүүддээ оффисын орчинд хэрэглэхэд тохиромжтой.



# АЗ ЖАРГАЛЫН АМТТАЙ



## BerryVit



Монгол орны үржил шимт хөрсөнд ургадаг байгалийн зэрлэг жимс болох Аньс, Нэрс, Чацаргана жимсэнд агуулагдах олон төрлийн аминдэм, эрдэс бодисуудыг хүүхэд багачууддаа зориулан Берривит брэндийн витаминт, үзэмтэй, ааруултай гэсэн нэр төрлийн үрлийг үйлдвэрлэдэг.



Берривит брэндийн үрлүүд нь Витамин С болон кальциар баялаг бөгөөд найрлагадаа химийн будагч бодис агуулаагүйгээрээ онцлогтой.



# БАЙГАЛИЙН БҮТЭЭЛ БАРАГШУН *өтөрцүцсэн*



**Б**арагшуныг уламжлалт анагаах ухаанд 3000 жилийн өмнөөс хэрэглэж ирсэн бөгөөд 400 гаруй өвчин эмгэгийг анагаах, урьдчилан сэргийлэх үндистай гэж үздэг. Хүний бие махбод нийт 90 орчим төрлийн эрдэс шаардлагатай байдаг бөгөөд үүнээс 60 орчмыг нь өдөр тутмын хоол хүнсээр авснаар аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжтой юм.

Барагшунд Натри, Кали, Кальци, Төмөр, Фосфор, Мангани зэрэг 30 орчим шимт эрдэс бодис, 6 төрлийн амин хүчлүүд мөн олон төрлийн биологийн идэвхт бодисууд агуулагддаг тул элэг, бөөр, цэс, эд эсийн нөхөн төлжилтийг эрчимжүүлэх, ясны хугаралт, бэртэнгийн эдгэрэлтийг түргэсгэх, хүний биеийн эрдэс тэжээлийн хэрэгцээг хангах, дархлаа сайжруулах, зүрх судасны эрхтэн системийн үйл ажиллагааг дэмжих, чихрийн шижин, ходоодны улайлт, шархлаа зэрэг өвчлөл, аливаа харшлын үед ууж хэрэглэснээр эмчилгээг дэмжих, урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.



## АНАГААГЧ

*Шидэм*  
• саримс •

**Ц**усан дахь холестерин хэмжээг бууруулан биеийг хоргуйжүүлэх, дархлааны системийн үйл ажиллагааг дэмжих, хорт хавдраас сэргийлэх, харшлын эсрэг үйлчилгээтэй учир харшлаас урьдчилан сэргийлэх, исэлдэлтийн эсрэг буюу антиоксидант үйлчилгээтэй учир эд эсийг нөхөн сэргээх бие махбодын эрдэс бодисын хэрэгцээг хангах үйлчилгээтэй.

Энгийн саримсыг ямар нэгэн химийн бодис холилгүйгээр тусгай исгэх зууханд 30 хоног исгэснээр энгийн саримсны өөх, тос, уураг, магни, цайр, натри зэрэг химийн элементүүдийг 30 дахин, хөгшрөлтийн эсрэг үйлчилгээг 20 дахин нэмэгдүүлдэг.



# ХАМГИЙН САЙН НЬ

# ХААН ЖИМС

Бид Дархан-Уул аймгийн Бүрэн толгойн Бүржил шимт хөрсөнд ургуулсан чацарганын тос, шүүс зэрэг бүтээгдэхүүнийг Хаан Жимс брэнд нэрийн дор үйлдвэрлэдэг. Үүнээс гадна эх орны хөрсөнд ургасан аньс жимсийг орон нутгийн бэлтгэн нийлүүлэгчдээс авч Хаан жимс брэндийн өтгөрүүлсэн болон шууд уух шүүс үйлдвэрлэж байна.



## ҮНДЭСНИЙ КОНТЕНТ МААМУУГИЙН БААТРУУД

Монгол уламжлал, ёс заншлыг таниулах хүүхдийн контентыг дэмжин “Монгол контент” ХХК-ийн “Маамуу” цуврал хүүхэддэйн киноны гол дүрийн өхөөрдөм 2 баатар болох “Аами, Таами”-гийн нэрээр байгалийн цэвэр жимсний ундааг бяцхан хэрэглэгчдэдээ зориулж байна. Хүүхдүүдийн хэзээний танил болсон амт чанартай, химийн бодис агуулаагүй Аами, Таами ундаа нь хэрэглэхэд хялбар, өнгө үзэмж сайтай савлагаатай болон худалдаанд гарлаа. Хүүхэд багачууд өдөр тутамдаа хэрэглэснээр хоногийн С амин дэмийн хэрэгцээгээ хангаж дархлаагаа дэмжин ханиаднаас урьдчилан сэргийлэх боломжтой.



## ХЭРЭГЛЭЭНД ХЯЛБАР Шинэчлэгдсэн савлагаа

Өдрийн Витамин С-ийн  
хэрэгцээг хангана

# ЭРҮҮЛ МЭНДИЙГ ЦЭНЭГЛЭГЧ

**VITOS**  
more health

Биологийн идэвхт эмийн ургамал, амин дэмийн агууламж өндөртэй жимснүүдийн тааламжит амтыг хослуулсан “Цэнэг” эрүүл мэндийн бэлдмэлийн шинэчлэгдсэн савлагаа бүхий Витос брэнд. Өдөр тутмын завгүй амьдралын хэв маягт тохирсон шууд уух зориулалттай эрүүл мэндийн бэлдмэл нь хэрэглээнд илүү хялбар, шинэ өнгө төрхтэйгээр дахин мэндэлж байна.

Байгалийн анагаах уддисыг орчин үеийн технологитой хослуулан бүтээгдсэн Витос эрүүл мэндийг бэлдмэлийг тогтмол хэрэглэснээр олон төрлийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмчилгээний үр дүнд эерэгээр нөлөөлөх онцгой ач холбогдолтой.

ХЭРЭГЛЭЭГ  
ХЯЛБАРЧИЛСАН  
БӨГЛӨӨ





# ТАСАРХАЙ АМТТАЙ



Сэнгэнэсэн, час хийсэн амтыг таалан хүртдэг хүмүүст зориулсан уусдаг цай Tastea. Цагаан гаа, турмерик, нимбэг, цайны ханд, зөгийн бал зэргийг тохирох тунгаар найруулан таатай амтыг хослуулсан бүтээл юм.

Дархлаагаа сэргээх, цусан дахь сахарын хэмжээгээ бууруулж цусны эргэлтээ сайжруулах болон хоол боловсруулах эрхтэн системээ дэмжихийг хүссэн хүн бүр хэрэглэхэд хялбар цай юм. Мөн өвдөлт намдаах, амны хөндийн эвгүй үнэрийг дарах, биеийн жин бууруулах ашиг тустай.



# БИЕИЙГ ХОРГҮЙЖҮҮЛЭХ

## УВДИСТ *Бэлдмэл*



Орчны бохирдол, хоол хүнс, амьсгалж буй агаар, хорт зуршил зэргээс хүний бие өдөр тутамдаа их бага хэмжээгээр бохирдож байдаг. Тиймээс Монос Хүнс ХК олон мянган жилийн турш туршигдан уламжлагдаж ирсэн биеийг хоргуйжүүлэх үйлдэл өндөр хунчир болон хар саримсыг ашиглан Увдист хэмээх эрүүл мэндийн бэлдмэлийг бүтээсэн юм.

### ХУНЧИРТАЙ УВДИСТ БЭЛДМЭЛ

Дорнын уламжлалт анагаах ухаанд олон мянган жил эмчилгээний зорилгоор хэрэглэсээр ирсэн эмт ургамлын хаан гэгддэг ХУНЧИР хэмээх энэхүү ургамал нь дархлаа дэмжих тамир сэргээх үйлдлээрээ алдартай. Үүнээс гадна хортой нөхцөлд их өртдөг элэг, мэдрэлийн тогтолцоо, бөөр, уушги, зүрх зэрэг эд эрхтний үйл ажиллагааг дэмжих үйлчилгээ үзүүлнэ.



### ХАР САРИМСТАЙ УВДИСТ БЭЛДМЭЛ

Хар саримс нь энгийн саримстай харьцуулахад хурц үнэргүй, чихэрлэг зөөлөн амттай болсноос гадна хүний биед хэрэгтэй химийн элементүүд нь 30 дахин, хөгшрөлтийн эсрэг үйлчилгээ нь 20 дахин илүү юм.

Мөн түүнчлэн цус шингэлж хавдраас сэргийлэх, дотор эрхтний үйл ажиллагааг сайжруулж биеийг хоргуйжүүлэх үйлдлийг үзүүлдэг. Учир нь энгийн саримс хар саримс болох явцдаа Хомоцестин хэмээх нэгдлийг өөртөө бий болгож энэ нь судасны ханан дахь хуримтлагдсан өөх тосны нэгдлүүдийг задлан судасны ханыг цэвэрлэдэг. Ингэснээр зүрхний цусан хангамжийн дутагдал, тархины цусан хангамжийн дутагдал, артерийн даралт ихсэх, зүрхний шигдээс, тархины саажилт зэргээс урьдчилан сэргийлэх боломжтой.



# ЧИХРИЙН МАНГАСААС ХАМГААЛАГЧ ЭРЭЛХЭГ ТУГАЛ

ЖИМСЭЙ ШАХМАЛ ААРУУЛ  
**ТУГАЛ**

Анх, нэрс, чацаргана жимсний амттай ТУГАЛ шахмал ааруул нь А, В, С, D аминдэм, уураг болон кальциар баялаг тул хүүхдийн өсөлт хөгжилт, яс шүдний бэхжилтийг дэмжих сайн нөлөөтэй. Чихрийн хэрэглээ өндөртэй хүүхэд багачуудын хувьд шүд хорхойтож цоорох, таргалах, диатизтай болох, дархлаа нь сулрах зэрэг эрүүл мэндийн олон сөрөг зүйлтэй тулгардаг. Харин уламжлалт цагаан идээг орчин үеийн технологитой хослуулсан Тугал шахмал ааруул нь хүүхдийн чихрийн хэрэглээг бууруулах, эрүүл мэндийг дэмжих бүтээгдэхүүн юм.



# НИЙГЭМД ҮЗҮҮЛСЭН ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ

Нийгмийн хариуцлагын хүрээнд “Монос хүнс” ХК эх орны ирээдүй болсон хүүхэд залуучууд, онцгой асаргаа хэрэгтэй хүмүүс, ахмадууд, эрүүл мэндийн туслалцаа хэрэгтэй байгаа хувь хүнрүү чиглэсэн ажлуудыг тогтмол болон тухайн цаг үед тааруулан зохион байгуулдаг. Бид 2020 оны эхний хагас жилд нийгмийн хариуцлагын дараах ажлуудыг амжилттай зохион байгууллаа.



## Хүүхэд бүр эрүүл, чин сэтгэлээсээ инээмсэглэж байг

Нийслэлийн гэр хорооллын хүнд нөхцөлд амьдардаг хүүхдүүдэд хоол хүнс хүргэх Лантуун Хүүгийн Богц аянд “Монос Хүнс” ХК өөрсдийн үйлдвэрлэдэг хүүхдийн эрүүл мэндийн бүтээгдэхүүнээрээ нэгдсэн юм.

## Анхаарал татсан халуун сэдэв COVID-19

Тусгай үүргийн онгоцоор Ухань хотоос эх орондоо ирсэн 31 оюутан, Монголын улсын бяцхан нэг иргэнд хандив өгөх үйл ажиллагааг санаачлан эхлүүлээ.



## Галын шугамд ажиллаж буй баатруудаа дэмжив

Тусгаарлагдсан иргэд, онцгой нөхцөл байдалд өргөсөн тангарагтаа үнэнчээр ажиллаж буй эмч сувилагч, онцгой байдлын албан хаагчдад өөрсдийн үйлдвэрлэдэг дархлаа дэмжив бүтээгдэхүүнүүдээр хандив өгөв. Мөн манай компанийн ажилтанууд урмын үгээ гараар бичин бүтээгдэхүүнийхээ хамтаар хүргүүлсэн билээ. Энэхүү хандивын үйл ажиллагаанд Монос группийн компаниуд нэгдэж нийт 60 сая төгрөгийн үнийн дүнтэй бүтээгдэхүүнийг хандивласан юм.


## Monos care аян

Тодорхой хугацаанд хэрэглээд хэрэгцээгүй болдог суга таягийг хэрэг болсон хүнд нь хүргэх үүднээс ГССҮТ-өөр эмчлүүлж буй ард иргэдэд үнэ төлбөргүй тараах аяныг хэрэгжүүлсэн. Аяны хүрээнд хувь хүн, албан байгууллага сайн дурын үндсэн дээр 4,5 сая төгрөгтэй тэнцэх 164 суга таягийг хандивлаж гэмтэж бэртсэн 91 хүнд тус хүргэсэн.



# КОМПАНИЙН СОЁЛ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨСӨЛТ ХӨГЖИЛТ

Манай ажилтан бүр Монос Хүнс компанийн үнэт зүйл, амжилтын үндэс суурь юм. Бид ажилтнуудынхаа хөдөлмөрийн орчинг таатай байлгах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, өрсөлдөхүйц цалин хөлсийг бий болгохоор зорин ажилладаг.



Ажилтнуудын дундаж нас: 32

## Тайсо дасгалын цаг

Хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, үе мөчний уян хатан байдлыг хадгалахад тустай маш энгийн 3 минутын дасгалыг хамтдаа хийдэг.



## Уян хатан цагийн систем

Ажилтнуудын сурч хөгжих, хувь хүний хэрэгцээ, эрх ашгийг үндэслэн ажил эхлэх болон дуусах цагийг 3 төрлийн сонголттой болгосон.

## Өглөөний цай

Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих зорилгоор Өглөөний цай хөтөлбөр хэрэгжүүлж байна.



## Номын сан

Мөн ажилтнуудын танин мэдэхүйн хэрэгцээг хангах ажилчдын номын санг нээн ажиллуулж байна.

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## ШИНЭ ҮЙЛДВЭРИЙН 1 САЯ ДАХЬ БҮТЭЭГДЭХҮҮН

4,000 гаруй хувьцаа эзэмшигчдийнхээ хамтаар олон улсын GMP стандартын бүрэн автомат Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрийг 2019 онд ашиглалтад оруулсан. Тус үйлдвэрийн үйл ажиллагаа эхлээд 1 сая дахь шинэчлэгдсэн савлагаатай “Экос зөөлөн ус”-ыг үйлдвэрлэн худалдаанд гаргав.



ЗӨӨЛӨН УС pH8.5

3 4 5 6 7 8 9 10 11



## ISO22000 СТАНДАРТ НЭВТРҮҮЛЭХ ТӨСЛИЙН БАГ БҮРДЛЭЭ

ISO 22000 Хүнсний аюулгүй байдлын тогтолцоо стандартыг Шингэн хүнсний үйлдвэрийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх зорилгоор төслийн багийг байгуулж үйл ажиллагааг эхлүүлэв. HACCP Хүнсний аюулгүй байдлын тогтолцоо, ISO9001:2015 Чанарын удирдлагын тогтолцоо стандартыг Хуурай хүнсний үйлдвэрийн үйл ажиллагаанд дахин баталгаажуулах ажлыг эхлүүлэв.

## “I” АНГИЛЛЫН ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЛОО

Монос Хүнс ХК 2019 оны 5-р сард олон нийтэд хувьцаагаа арилжаалж эхэлсэн бөгөөд өнгөрсөн нэг жилийн хугацаанд компанийн үйл ажиллагаа, ашиг орлого өсөн нэмэгдэж, хувьцаат компанийн засаглалын зарчмыг мөрдөн ажилласнаар “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-ийн хувьцааны бүртгэлийн II ангиллаас дэвшин I ангилалд бүртгэгдлээ.



Монголын Хөрөнгийн Биржийн  
I ангилалд бүртгэгдлээ

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛАА ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАВ

Монос Хүнс ХК 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлаа амжилттайгаар зохион байгууллаа. Энэ удаагийн хурал дэлхий дахинд үүсээд буй Ковид-19 вирусийн тархалттай холбоотойгоор цахим хэлбэрээр хийгдсэн бөгөөд хурлын үеэр “Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэр”-тэй виртуал аялал хийх боломж олгосноороо онцлогтой юм.

## КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ӨРГӨЖСӨӨР БАЙНА

Дэлхийн нийтийг хамарсан Ковид-19 вирусийн цар тахлын энэ хүнд нөхцөл байдал нь бизнесийн орчинд таатай бүс нөлөөлөл үүсгэж байгаа хэдий ч бидний хувьд шинэ үйлдвэрээ ашиглалтад оруулснаар ажлын байраа өмнөх оны мөн үеийнхээс 36%-аар буюу 48 шинээр ажлын байр нэмэгдүүлсэн байна.

36%↑



## АНУ-Д АЛБАН ЁСООР ЭКСПОРТ ХИЙХ БОЛОМЖТОЙ БОЛЛОО

АНУ-ын Эрүүл мэндийн яамны харьяа FDA буюу Food and drug administration байгууллага Монос Хүнс ХК-ийг Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрлэгч хэмээн бүртгэсэн бөгөөд ингэснээр АНУ-д албан ёсоор экспорт хийх үүд хаалга нээгдэв.

## ДЭЛХИЙН ОНЛАЙН ХУДАЛДААНЫ ЗАХ ЗЭЭЛД НЭВТРЭВ

Монгол орны үржил шимт хөрсөнд ургасан чацаргана жимсийг тусгай технологиор боловсруулан бүтээсэн чацаргана жимсний 100 хувийн цэвэр тос дэлхийн хамгийн том цахим дэлгүүр Amazon.mn сайт дээр байршин худалдаалагдаж эхэллээ. Мөн АНУ-д үйл ажиллагаагаа явуулдаг monchoiceglobal.com онлайн дэлгүүрт эрүүл мэндийн 6 брэндийн 17 төрлийн бүтээгдэхүүнийг байршуулав.


available at  
amazon




# 2020 ОНЫ БИЗНЕСИЙН ӨСӨЛТ ХӨГЖИЛ

Үйл ажиллагааны голлох үзүүлэлтүүд /хагас жил/


Борлуулалтын орлого /Сая₮/




Цэвэр ашиг /Сая₮/



Борлуулалтын цэгийн тоо



EBITDA /Сая₮/



Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу 2018 оны хагас жилээр хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл хийгдэж, элэгдлийн зардал өссөн. Уг дахин үнэлгээтэй холбоотой элэгдлийн зардал нь 2018 онд хагас, 2019 онд бүтэн жилээр тооцогдсон тул 2019 оны цэвэр ашиг 2018 оноос буурсан.



# ХУВЬЦААНЫ ХАНШИЙН МЭДЭЭЛЭЛ

Монос Хүнс ХК-ийн хувьцаа Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индексэд, зах зээлийн үнэлгээгээр ТОП-0 компанийн жагсаалтад багтлаа. Жилийн арилжааны мэдээллийг дараах графикаар үзүүлээ.


2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХАНШИЙН МЭДЭЭ

**73.9** Хамгийн дээд ханш **63** Хамгийн доод ханш

**70.3** Нээлтийн ханш **65** Хаалтын ханш

**2,955,962** Арилжааны ширхэг

**200,593,759** Арилжааны үнийн дүн



Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компаниудыг зах зээлийн үнэлгээ, арилжааны өдрийн дундаж гүйлгээ, арилжаанд орсон өдрийн тоо, төвлөрлийн байдал зэрэг үзүүлэлтүүдээр үнэлж, ТОП-20 индексийн багцыг жилд 1 удаа шинэчлэн тооцоолдог. 2020 оны ТОП-30 индексийг бүрдүүлэгч компаниудыг 2019 оны сүүлд тодорхойлсон бөгөөд хоёрдогч зах зээлд гарснаасаа хойш Монос Хүнс компанийн /MFC/ хувьцаа 2,955,962 ширхэг арилжаалагдаж ТОП-20 индексэд багтсан байна.

№	СИМБОЛ	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	ХААЛТЫН ХАНШ	ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ
1	TTL	Таван толгой ХК	5,415	285,182,058,000
2	GOV	Говь ХК	192	149,586,571,875
3	APU	АПУ ХК	580	617,225,300,740
4	SUU	Сүү ХК	207	71,208,000,000
5	LEND	ЛэндМН ББСБ ХК	32	25,968,000,000
6	MNP	Монгол шуудан ХК	599	59,652,231,437
7	MBW	Монгол Базальт ХК	191	10,775,647,000
8	AIC	Ард Даатгал ХК	715	17,875,000,000
9	MNDL	Мандал Даатгал ХК	41	25,858,572,272
10	BDS	Би ди сек ХК	950	13,010,138,850
11	AARD	Ард санхүүгийн нэгдэл ХК	1,250	35,767,828,750
12	MIK	Мик холдинг ХК	12,990	269,014,066,800
13	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	618	9,729,242,570
14	ADB	Ард кредит ББСБ ХК	68	19,166,000,000
15	ERDN	Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК	1,021	4,084,000,000
16	INV	Инвескор ББСБ ХК	2,538	182,045,455,884
17	<b>MFC</b>	<b>Монос хүнс ХК</b>	<b>64</b>	<b>26,064,214,785</b>
18	SHG	Шарын гол ХК	1,255	8,997,307,990
19	TUM	Түмэн шувуут ХК	167	31,406,000,000
20	UID	Улсын их дэлгүүр ХК	1,138	32,390,908,000

# САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /Мянга₮/	2020 оны I хагас жил	2019 оны I хагас жил
<b>ХӨРӨНГӨ</b>	<b>21,584,337</b>	<b>22,156,335</b>
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>5,330,775</b>	<b>10,650,317</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	136,219	3,591,594
Дансны авлага	2,020,274	1,492,101
Татвар, НДШ – ийн авлага	21,920	6,861
Бусад авлага	86,536	165,563
Бараа материал	2,419,773	1,590,349
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	646,053	3,803,850
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>16,253,562</b>	<b>11,506,018</b>
Үндсэн хөрөнгө	14,382,569	7,888,808
Биет бус хөрөнгө	1,833,860	3,606,500
Хойшлогдсон татварын хөрөнгө	37,133	10,710
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>21,584,337</b>	<b>22,156,335</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,737,955</b>	<b>4,963,148</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,337,723</b>	<b>1,628,802</b>
Дансны өглөг	465,378	222,452
Цалингийн өглөг	42,268	32,593
Татварын өр	238,555	192,169
НДШ - ийн өглөг	23,955	23,160
Богино хугацаат зээл	478,073	-
Хүүний өглөг	246,639	953,452
Ногдол ашгийн өглөг	408,850	-
Урьдчилж орсон орлого	5,960	12,240
Бусад богино хугацаат өр төлбөр	428,045	192,736
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,400,232</b>	<b>3,334,346</b>
Урт хугацаат зээл	3,334,346	3,334,346
Бусад урт хугацаат өр төлбөр	65,886	-
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>15,846,382</b>	<b>17,193,187</b>
<b>Өмч</b>	<b>15,846,382</b>	<b>17,193,187</b>
Хувьцаат капитал	2,318,182	2,318,182
Нэмж төлөгдсөн капитал	6,835,733	6,849,333
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,076,575	6,529,417
Хуримтлагдсан ашиг	2,615,891	1,496,254

# ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН /Мянган₮/	2020 он I хагас жил	2019 он I хагас жил
Борлуулалтын орлого (цэвэр)	5,435,420	4,610,181
Борлуулалтын өртөг	2,964,094	2,554,088
<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>2,471,326</b>	<b>2,056,093</b>
Түрээсийн орлого	1,270	2,438
Хүүний орлого	3,407	85,897
Бусад орлого	82,764	1,933
Борлуулалт, маркетингийн зардал	1,235,563	1,003,516
Ерөнхий ба удирдлагын зардал	620,815	547,268
Санхүүгийн зардал	132,126	137,369
Бусад зардал	106,449	61,920
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(5,921)	(7,795)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(1,547)	-
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>456,346</b>	<b>388,493</b>
Орлогын татварын зардал	56,426	49,734
<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>399,919</b>	<b>338,759</b>



+976 77773525



Info@monosfoods.mn  
www.monosfoods.mn



Хан-Уул дүүрэг, 2-р хороо,  
17043 Чингисийн өргөн чөлөө  
Улаанбаатар хот, Монгол Улс